МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

# МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ ДАГАСАН ХУУЛЬ, ТОГТООМЖ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 40% орчимд тогтворжих төсөөлөлтэй байна.**

*ЗГ-ын өрийн дунд хугацааны төсөөлөл*
*(ДНБ-д эзлэх хувь)*




**Өрийн тогтвортой байдлын шинжилгээ**

2023 онд **Өндөр эрсдэлтэй** → 2025 онд **Хэвийн эрсдэлтэй**

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2026-2028 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

### ЗОРИЛТУУД

**1** — 3 арга хэмжээ

Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан, **эдийн засгийн бодит өгөөжтэй**, тэргүүлэх ач холбогдол бүхий **төсөл, хөтөлбөрүүдийг** тэргүүн ээлжид хэрэгжүүлэх бодлогыг баримтална.

**2** — 2 арга хэмжээ

Засгийн газрын өрийн **оновчтой удирдлагыг хэрэгжүүлж**, дунд болон урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор **өрийн зохицуулалтын арга хэмжээг** авч хэрэгжүүлнэ.

**3** — 2 арга хэмжээ

Болзошгүй өр төлбөрийн **эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх** зорилгоор аймаг, нийслэлийн үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлана.

**4** — 2 арга хэмжээ

Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулан **зах зээлийн суурь хүүг тогтоох** замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж, **хөрөнгө оруулагчдын бааз суурийг тэлнэ.**

# ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ

## МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ “ФИТЧ” АГЕНТЛАГ “B+/ТОГТВОРТОЙ” ХЭВЭЭР ХАДГАЛЛАА

| | 2024 ОН | | 2025 ОН |
|---|---|---|---|
| Fitch Ratings /2024.09.18/ | B+ тогтвортой | → | B+ тогтвортой /2025.09.01/ |
| S&P Global Ratings /2024.10.03/; Moody's /2024.11.18/ | B+ зэрэг B2 тогтвортой | | 2025 он ⌛ |

**Монгол Улсын зээлжих зэрэглэл 2024 онд буюу 10 жилийн дараа B+ түвшинд буцаж хүрсэн**

## МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛЫГ ЭЗХАХБ-ААС НЭГ ШАТ АХИУЛЛАА




7 → 6

- ✓ **САНХҮҮЖИЛТИЙН ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ:** Улсын эрсдэлийн ангилал сайжирснаар ЗГ болон хувийн хэвшлийн санхүүжилтийн зардал буурна.
- ✓ **ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ТААТАЙ НӨХЦӨЛ:** Экспортын зээлийн баталгааны нөхцөл сайжирснаар Монголын үйлдвэрлэгч, экспортлогчдын олон улсад өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
- ✓ **ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДЭХ:** Хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, Монгол Улсад хөрөнгийн орох урсгалыг дэмжинэ.

**Засгийн газар болон хувийн хэвшилд гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ санхүүжилтийн өртгийг бууруулах таатай нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.**

# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**Засгийн газрын үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай**

1.Монгол Улсын Засгийн газраас 2026 онд Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-т заасан зориулалтаар 561.2 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас, мөн зүйлийн 12.1.4-т заасан зориулалтаар 1.0 тэрбум ам.доллар хүртэлх гадаад үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т олгосугай.

### Хэрэгцээ шаардлага:

**ӨУТХ 26.3:** Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргахтай холбогдсон аливаа шийдвэрийн төслийг энэ хуулийн 8.2.4-т заасныг үндэслэн Засгийн газарт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд Засгийн газар оруулна.

### Гадаад үнэт цаас: 1.0 тб $

*(Дахин санхүүжүүлэх)*

### Дотоод үнэт цаас: 561.2 тб ₮

*(Улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдал, дотоод үнэт цаасны зах зээл дэмжих)*

### ЗГ-ын өрийн удирдлагын 2026-2028 стратеги зорилт 4

- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэн, арилжааг тогтмол зохион байгуулна.
- Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, боломжит хэмжээг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд төсөл, хөтөлбөр, төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор арилжаалахгүй.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

## Эрсдэлийн нэмэгдэл (спред)




## ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮҮ




**Дахин санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр ач холбогдол:**

1. Гадаад төлбөрийн дарамтыг бууруулна
2. Зах зээлд аж ахуйн нэгжүүдийн суурь хүүг тогтооно
3. Хувийн хэвшлийн олон улсын зах зээлд боонд гаргах боломжийг нэмэгдүүлнэ.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

## ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

**ЗГДҮЦ-ны 3-р улирал арилжаа**
/2025.04.16-ны өдрөөс эхэлсэн/

2025.10.01-нийг хүртэл арилжаалсан хэмжээ: **108.0 тб ₮**

Ирсэн саналын хэмжээ: **322.1 тб ₮**




### ӨГӨӨЖИЙН МУРУЙ




### АРИЛЖААНД ОРОЛЦОГЧИД




## АЧ ХОЛБОГДОЛ

Хөрөнгийн зах зээлд **суурь хүү** буюу өгөөжийн муруй тогтоох

Хөрөнгө оруулагчдад **эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай** санхүүгийн хэрэгсэл санал болгох

Аж ахуйн нэгжүүдийн гаргах үнэт цаасны **хүүг бодитоор тогтоох**

**Гадны хөрөнгө оруулалтыг** дотоодын зах зээлд татах

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# НӨАТ-ЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

# ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЧИГЛЭЛ

1

## ТАТВАРЫН АЧААЛЛЫГ БУУРУУЛАХ

ИРГЭДИЙН ОРЛОГЫГ ХАМГААЛАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ:

- *Иргэн, өрхийн **орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэхийг** дэмжсэн татварын хөнгөлөлт үзүүлж, татварын ачааллыг бууруулна*

БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ:

- *Бизнесүүдийн **тогтвортой үйл ажиллагаа** явуулах, **хуримтлал үүсгэх, өргөжүүлэх** нөхцөлийг бүрдүүлнэ*

2

## ТАТВАРЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

- ***Хариуцлагатай татвар төлөгчийг дэмжиж,** татварын өр барагдуулах үйл ажиллагаанд данс бүрэн хаадгийг зогсооно*

- ***Бүх нийтээрээ жигд, тэгш шударга** төлдөг тогтолцоог бүрдүүлнэ*

- *Татвар төлөгчдөд **зөвлөн тусалдаг**, татварын **эрсдэлээс урьдчилан сэргийлдэг** болно*

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ: ОЛОН НИЙТИЙН САНАЛ

## УЛС ОРОН ДАЯАР 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 27-НООС ЭХЛЭН ХУУЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, БҮХ НИЙТИЙН САНАЛ АВСАН

### БҮХ САЛБАРЫН ТӨЛӨӨЛЛИЙГ ХАМРУУЛЖ БАЙНА

- Татвар төлөгч иргэн, ААН
- Эрдэмтэн судлаачид
- Төрийн бус байгууллагууд
- Мэргэжлийн холбоод г.м

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ ТАЛУУД:

- Улсын Их Хурлын Тамгын газар
- Татвар, гаалийн байгууллага
- Худалдааны танхимууд
- Мэргэжлийн холбоод
- МҮХАҮТ




ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БИЕЭР **13,000 ГАРУЙ ИРГЭН, ААН** ОРОЛЦОЖ, **170,000 САНАЛ** АВСАН

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# НӨАТ-ЫН ИРГЭДИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ ХУДАЛДАН АВАЛТЫН ХЭМЖЭЭНЭЭС ХАМААРЧ ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛНЭ



ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ **DPARLIAMENT, LEGALINFO-д** байршуулан олон нийтийн хэлэлцүүлгийг эхлүүллээ

**2026 оноос**

*Нийт худалдан авалтын **75 хувь** хамрагдана*

| | |
|---|---|
| 1 сая хүртэл | 5% |
| 1 саяас дээш | 2% |

**БУЦААН ОЛГОНО**

**2027 оноос**

| | |
|---|---|
| 500 мян. хүртэл | 10% |
| 500 мян. - 1 сая | 5% |
| 1 саяас дээш | 2% |

**БУЦААН ОЛГОНО**

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# ХЭРЭВ НӨАТ-ЫН 10%-5% БОЛГОВОЛ

**ИРГЭД**

**75%**

**25%**

ТӨСВИЙН НӨЛӨӨ **4** их наяд₮




"ГОЛЛАНД ӨВЧИН“

*Голланд улсад 1959 онд байгалийн хийн томоохон орд нээгдэж, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж, Голландын аж үйлдвэрийн салбар уналтад орсон.*

# НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР – ОЛОН УЛСАД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ




## НӨАТ-ЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

**1948** Франц улсад анх нэвтэрсэн

**1954** Бөөний худалдаанд нэвтэрсэн

**1968** Жижиглэн худалдаанд нэвтэрсэн

**1998** Монгол улсад анх нэвтэрсэн

**2016** Монгол улсад урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн

**ОЛОН УЛСАД ТӨСВИЙН ОРЛОГЫН ¼-ИЙГ НӨАТ БҮРДҮҮЛЖ БАЙНА**

**НӨАТ-ай улс 175**

**9** **Монгол улсаас бага хувь хэмжээтэй улс** — Андорра, Тайван, АНЭУ, Зүүн Тимор, Тайланд, Панам, Нигери, Оман, Жерси арлууд

**15** **НӨАТ-гүй улс орнууд** — Хонгконг, Макао, Бермуда, Британийн Виржиний арлууд, Кайманы арлууд, Гренланд, Гибралтар, Төркс ба Кайкосын арлууд,

**7** **2026-2027 онд НӨАТ нэвтрүүлэхээр төлөвлөж буй улс орнууд** — Кувейт, Катар, Аруба, Гернси, Бутан, Малайз, Ливи

## НӨАТ-ын хувь хэмжээ

| 4.5% – 8% | 8% – 16% | 16.5% – 27% |
|---|---|---|
| 9 улс | 76 улс | 90 улс |

**НӨАТ-ЫН ДЭЛХИЙН ДУНДАЖ 16%**